

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА.**

Гүйцэтгэх үүрэг:

- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж гаргах, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, чанарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжилтийг хангахад мэргэжлийн арга зүй, удирдлагаар хангах;
- Хөндлөнгийн хяналт шинжилгээний баг, эмнэлгийн чанарын баг, мэргэжлийн салбар зөвлөл, хороо, комисстой хамтарч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, журмыг шинэчилж боловсруулах, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах олон улсын туршлагыг нэвтрүүлэх, тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх технологи, инновацийн ажлуудыг олон улсын түвшинд хүргэхэд стратегийн чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

Тавигдах шаардлага:

- Анагаах ухааны их дээд сургуулийг хүний их эмч мэргэжлээр төгссөн;
- Анагаах ухааны магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй;
- Эмчлэх эрхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт 10-аас дээш жил ажилласан байх;
- Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэдлэг, туршлагатай;
- Удирдах албан тушаал эрхэлж байсан байх;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай
- Эрүүл мэндийн удирдлага болон удирдахуйн ухааны чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн байх;
- Гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
- Эерэг хандлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвартай байх;

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн 1-р маягт /3*4 цээж зураг-2%/
- Боловсролын түвшинг тодорхойлсон бүх баримт бичгүүд /нотариатаар гэрчлүүлсэн байх/
- Эмчлэх эрхийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /Нотариатаар гэрчлүүлсэн байх/
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл

Дээрх шаардлагыг бүрэн хангасан материалыг УНТЭ-ийн Захиргааны 5 давхарт 504 тоот өрөө, Захиргаа, хүний нөөцийн албанд 2020.10.26-ны өдрийг дуустал хугацаанд хүлээн авна. Утас:77111017

Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион явуулна. Үүнд:

1. Баримт бичгийн шалгаруулалт
2. Онолын шалгалт
3. Ярилцлагын шалгалт